

## **“ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭНД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ИЛТГЭХ ХУУДАС**

### **Нэг. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үндэслэл**

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2008 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тус газраас “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээг хийсэн болно.

### **Хоёр. Хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлал**

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолоор батлагдсан “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр” нь хэрэгжээд 2 жил болж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Үндэсний зөвлөлийн ажлын тайлан, хөтөлбөрт тодорхой үүрэг хүлээхээр заагдсан байгууллагуудаас авч хэрэгжүүлсэн ажлын тайлангуудыг үндэслэн, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг заалт бүрээр гарган, Засгийн газрын 2006 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу үнэлгээ өгч, хүрсэн түвшинг 2008 оны 12 сарын 1-ний байдлаар гаргалаа.

### **Гурав. Хөтөлбөрийн хэрэгжилт**

#### ***3.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт***

“Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 155 дугаар тушаалаар Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг хариуцсан Үндэсний зөвлөлийг байгуулж, журмыг баталсан байна.

Зөвлөлийн бүрэлдэхүүнд Хүний эрхийн үндэсний комисс, Монголын өмгөөлөгчдийн холбоо, МУИС-Хууль зүйн сургууль, Шүүхийн ерөнхий зөвлөл зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл болох 13 гишүүн ажиллаж байна.

Үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг батлан, нийт аймаг, нийслэл, дүүргүүдэд салбар зөвлөл байгуулан, Үндэсний зөвлөлийн хурлыг улирал тутам зохион байгуулж эрх зүйн туслалцаа, сургалт сурталчилгааны ажлыг бодлогын удирдамж болон арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан байна.

#### ***3.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал***

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 6 үндсэн зорилтын хүрээнд нийт 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнээс: 2008 оны 12 дугаар сарын байдлаар хэрэгжиж дууссан байх ёстой 7 арга хэмжээ, хэрэгжих шатандаа 5, хугацаа болоогүй 1 арга хэмжээ байна. 2006-2008 онуудад эхлүүлсэн байхаар төлөвлөгдсөн 6 арга хэмжээнээс тасарсан заалт байхгүй боловч зарим арга хэмжээ эхэлсэн төдий байна. Хойшид эдгээр ажлуудыг үлдсэн хугацаанд нь багтаан хэрэгжүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна.

Тухайлбал:Төлөвлөгөөний 3.1-д “Эрх зүйн үнэ төлбөргүй туслалцааны чанарын болон хяналтын стандартыг Эрх зүйн туслалцааны төвүүдтэй хамтран боловсруулж батлуулан мөрдүүлэх” гэсэн заалт нь 2006 оноос эхлэн хэрэгжих боловч тодорхой ажил хийгдээгүй байна.

Мөн төлөвлөгөөний 5.1, 5.2-д заасны дагуу Хуулийн сургуулийн клиник сургалтын төвийн нөөц бололцоог ашиглах, хуулийн сургуулийн төгсөх ангийн оюутнууд болон шинэ төгсөгчдийг төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажилд өргөнөөр оролцуулах ажлыг дэс дараатайгаар зохион байгуулах, хуулийн сургуулиудыг хууль зүйн клиниктэй болгох боломжийг судлах зэрэг заалтуудын хүрээнд хийгдэх ажлууд эхэлсэн төдий байна.

Төлөвлөгөөний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр гарган хувь, оноог өгч хавсаргав.

### **Үйл ажиллагаануудын биелэлтийг зорилт тус бүрээр гаргавал:**

1 дэх зорилт: Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоог боловсронгуй болгох, туршилтын журмаар ажиллаж байгаа Эрх зүйн туслалцааны төвийг дэлгэрүүлэх- **75%**

### **Хийгдсэн ажлуудаас товч дурдвал:**

❖ “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд Сайдын 2007 оны 155 дугаар тушаалаар Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг хариуцсан Үндэсний зөвлөлийг байгуулж, журмыг батлуулсан байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Хүний эрхийн үндэсний комисс, Монголын өмгөөлөгчдийн холбоо, МУИС-Хууль зүйн сургууль, Шүүхийн ерөнхий зөвлөл зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл болох 13 гишүүн ажиллаж байна. Үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг батлаж, нийт аймаг, нийслэл, дүүргүүдэд салбар зөвлөл байгуулагдсан байна. Үндэсний зөвлөлийн хурлыг улирал тутам зохион байгуулж эрх зүйн туслалцаа, сургалт сурталчилгааны ажлыг бодлогын удирдамж болон арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан байна.

❖ 2008 оны 4-р сард Хэнтий, Өвөрхангай аймаг, Баянзүрх, Баянгол дүүрэгт, бусад аймаг, дүүрэгт 8-р сард, нийт 29 “Эрх зүйн туслалцааны төв”-байгуулан үйл ажиллагаа явуулж, Эрх зүйн туслалцааны төвд ажиллах орон тооны 29 өмгөөлөгчтэй Үндэсний зөвлөлийн ажлын албанаас /ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/ гэрээ байгуулан ажиллаж байна.

❖ Аймаг, нийслэлийн дүүргийн Эрх зүйн туслалцааны төвүүдэд нийт 29 орон тооны өмгөөлөгчийн ажлын байр бий болгож, тогтмол үйл ажиллагаа явуулж, Засаг даргын тамгын газруудаас байр, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс техник, тоног төхөөрөмжөөр ханган, бичиг хэрэг, холбоо харилцааны зардлыг санхүүжүүлэн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

❖ Эрх зүйн төвүүд байгуулагдаад 4-8 сар болж байна. Төвүүдийн цаашдын тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор улсын төсвөөс цалингийн зардлыг санхүүжүүлэхээр шийдвэрлүүлсэн байна.

2 дахь зорилт: Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулсан хууль эрх зүйн актын төсөл боловсруулах- **60%**

❖ Өмгөөллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх өмгөөллийн үйлчилгээ, Үндэсний зөвлөлийн статусын талаар тусгагдсан байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2008 оны 27 дугаар тушаалаар “Эрх зүйн туслалцааны төвийн дүрэм”-ийг баталсан бөгөөд уг дүрэмд ЭЗТТ-ийн чиг үүрэг, хамрах хүрээ, өмгөөлөгч, эрх зүйн ажилтны эрх үүрэг, өмгөөлөгч шалгаруулах журам зэргийг тусгасан байна.

Төрийн нарийн бичгийн даргын 2008 оны 140 дүгээр тушаалаар “Эрх зүйн туслалцааны төвийн тайлангийн маяг”-ыг баталсан бөгөөд эдгээр баримт бичгүүдийн дагуу Төвүүдийн үйл ажиллагааг зохион байгуулсан байна

3 дахь зорилт: Төлбөрийн чадваргүйд тооцох аргачлалыг боловсронгуй болгох, эрх зүйн туслалцааны чанарын болон хяналтын стандартыг боловсруулан мөрдүүлэх- **60%**

❖ Төлбөрийн чадваргүй иргэдийн судалгааг аймаг тус бүрээр нь жагсаан гаргаж эрх зүйн туслалцааны төв байгуулах төлөвлөгөөнд ашигласан бөгөөд мөн Төвүүд харьяа дүүрэг, хороо, аймаг, сумынхаа энэ чиглэлээрх судалгааг нийгмийн халамжийн ажилтан, Засаг даргаас гаргуулан авч ажиллаж байна. Үндэсний зөвлөлийн дүрэм, өмгөөлөгчдийн гарын авлагыг бэлтгэхэд ӨАБНУ, Молдав, Унгар зэрэг улсуудын холбогдох баримт бичгүүдийг судалсан бөгөөд Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд

багтдаг байгууллагуудын удирдлага БНЭУ-д ажлын айлчлал хийж туршлага солилцсон байна. Үндэсний статистикийн газрын дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 77/71 дүгээр хамтарсан тушаалаар төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох шалгуур үзүүлэлтийг маш нарийн тогтоосон байдаг тул дахин давхардуулан боловсруулах шаардлага одоогоор байхгүй гэж Үндэсний зөвлөлөөс үзсэн байна.

4 дэх зорилт: Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бий болгох асуудлыг судлан шийдвэрлүүлэх- **73%**

❖ Холбогдох тооцоог хийсний үндсэн дээр улсын төсөвт энэ чиглэлээр 2008 онд 15 сая төгрөгийг өмгөөлөгчдийн цалингийн зардалд зарцуулж, 2009 оны улсын төсөвт 78 сая төгрөгийг тусгасан байна. Үндэсний хөтөлбөрт заасан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран ажиллахаар харилцан зөвшилцөж НҮБ-ын суурин төлөөлөгч Пратиба Мета болон ХЗДХ-ийн сайд Д.Одбаяр нар 2007-2009 онд хэрэгжүүлэх 500 мянган ам.долларын төсөв бүхий “Хүний эрх ба хууль зүйн үйлчилгээний хүртээмж” төслийн баримт бичигт гарын үсэг зурсан байна. Уг төслийн хүрээнд эрх зүйн туслалцааны төвүүдэд техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийх, сургалт, сурталчилгаа явуулах зэрэг ажлуудыг хийж байна. Нийт 120.0 мянган ам.долларыг Төвүүдийн техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад, бичиг хэрэг, холбоо харилцааны урсгал зардалд 18.0 мянган ам.долларыг, Нээлттэй нийгэм форум, Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран ажиллах гэрээ байгуулан Төвийн өмгөөлөгчдийн цалингийн зардлын санхүүжилтэнд 25.0 мянган ам.долларыг тус тус зарцуулсан байна. Дээрх олон улсын байгууллагууд нь цаашид үргэлжүүлэн хамтран ажиллах чиглэлээр санал солилцож, төлөвлөгөө боловсруулахаар шийдвэрлэсэн байна.

❖ Орон нутаг дахь салбар зөвлөлүүдийн бүрэлдхүүнд тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл ажиллаж байна. ХЗДХЯ-аас Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүд, хүүхдийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх 5 түр хоргодох байр ажиллуулж эхэлсэн байна. Нийслэлийн төвийн дүүргийн Засаг даргын Тамгын газрууд болон бусад төрийн бус байгууллагуудтай хамтран эрх зүйн сургалт, сурталчилгааны нээлттэй өдөрлөгийг 6-р сарын 19-ны өдөр зохион байгуулсан байна. Өдөрлөгийн ач холбогдол нь иргэдэд эрх зүйн албан бус сургалт, сурталчилгаа, хууль тогтоомжийн лавлагаа, зөвлөгөө, мэдээллийг цогц байдлаар нь нээлттэй, үнэ төлбөргүйгээр “нэг цэгийн үйлчилгээ” хэлбэрээр хүргэхийн сацуу эрх зүйн сургалт, сурталчилгаа, хүний эрхийн чиглэлээр ажилладаг байгууллагуудын үйл ажиллагааны талаар иргэдэд тодорхой хэмжээний мэдээлэл өгсөн байна. Нийт 90 гаруй иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгч, 50 гаруй иргэн эрх зүйн албан сургалт явуулж, 150 гаруй эрх зүйн актын лавлагаа өгч, 1000 нугалбар хуудас түгээсэн байна.

❖ Төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөллийн туслалцаа үзүүлсэн өмгөөлөгчдийн хөлсийг МӨХ-оор дамжуулан ХЗДХЯ-аас туслалцаа үзүүлсэн тухай холбогдох баримт материалд үндэслэн олгодог байсныг 2008 оноос уг тогтолцоог өөрчлөн тогтсон тодорхой хугацаанд өмгөөлөгчдийн цалингийн картын дансанд ХЗДХЯ-аас шууд шилжүүлэн өгч байна.

5 дахь зорилт: Орон нутагт эрх зүйн мэдээлэл, лавлагаа, хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх- **40%**

❖ Одоогийн байдлаар нэр бүхий зарим хууль зүйн сургуулиуд дээр /МУИС, Отгонтэнгэр Их сургууль, Шихихутаг дээд сургууль/ -иуд хуулийн байгууллагад дадлагажигч оюутан ажиллуулдаг байна. Энэ асуудлаар цаашид ямар арга хэмжээ авах талаар судалгаа явуулахад дадлагажуулагч байгууллага ажлын байр нөхцөлийн хувьд боломжгүй байдаг, мөн оюутнуудыг хүлээн авч дадлагажуулах, клиник сургалт явуулахад тухайн байгууллагын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг тодорхойлж байдаг эрх зүйн баримт бичгүүдэд өөрчлөлт оруулах шаардлагатай байна гэсэн дүгнэлт гарсан байна. 2008 оны 10 дугаар сараас Хууль зүйн клиникүүдийн нийгэмлэг байгуулагдан анхны хурлаа хийж цаашид хийх ажлын төлөвлөгөө гарган ажиллахаар бэлтгэгдсэн байна.

❖ Хууль зүйн клиник сургалтын хэлбэрийг хэвшүүлэх, хамрах хүрээ, арга хэлбэрийг өргөжүүлэх, хамтын ажиллагааг идэвхижүүлэх гарцыг илрүүлэн гаргах зорилгоор нийслэлд ажилладаг 346 хуульчдийн дунд судалгаа явуулсан байна. Судалгааны дүнгээр клиник сургалтын талаар мэднэ гэж 207, үлдсэн буюу 139 нь мэдэхгүй гэж хариулсан байна. Цаашид хууль зүйн клиник сургалтын салбар байгуулагдан оюутнуудыг дадлагажих хөтөлбөр хэрэгжүүлэх, кредит цаг тооцвол идэвхтэй оролцох боломжтой гэсэн судалгааны дүнд үндэслэн тодорхой ажлуудыг хийхээр төлөвлөсөн байна.

❖ Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд зориулсан “Иргэдийн эрх зүйн хөтөч” гарын авлагыг эрх зүйн сургалт, сурталчилгааны ажилтнууд, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчид, бусад хууль зүйн шинжлэх ухааныг сонирхогчдод зориулсан “Эрх зүйн хөтөч-арга зүй” гарын авлагын хамт гаргасан байна. Эдгээр номнууд нь иргэдийн ахуй амьдралд хамгийн түгээмэл хэрэглэгддэг, нэн тэргүүнд мэдвэл зохих салбар эрх зүйн асуудлуудыг багтаасан чухал ач холбогдолтой, шинэлэг, цогц бүтээл болсон байна. Энэхүү ном нь бусад улс орнуудын иргэдийн эрх зүйн боловсролын “Street law” номын аргачлалын дагуу хийгдсэн ба Монголын эрх зүйн тухайн салбарын 20 гаруй багш, шинжээчид боловсруулсан байна. Сурах бичгүүдийг 22 аймаг, 9 дүүрэг, нийслэлийн ЗДТГ-ууд, 338 сум, 133 хороо, 20 төрийн болон төрийн бус байгууллагад хүргүүлсэн байна. ЗДТГ-ын эрх зүйн сургалт, сурталчилгааны

ажилтнууд нь уг номнуудын дагуу эрх зүйн албан бус сургалт тогтмол зохион байгуулж ХЗДХЯ-д мэдээ, тайлангаа ирүүлж байна. Мөн дээрх номнуудыг CD ном хэлбэрээр бэлтгэн хэвлүүлж, бүх сум, хороодод хүргүүлсэн байна. ЗДТГ-ын эрх зүйн сургалт, сурталчилгааны ажилтнууд нь уг номнуудын дагуу эрх зүйн албан бус сургалт тогтмол зохион байгуулж ХЗДХЯ-д мэдээ, тайлангаа ирүүлсэн байна. Мөн дээрх номнуудыг бие даасан вэб сайт болгохоор бэлтгэж байна.

❖ Эрх зүйн туслалцааны төвийн сургалт, сурталчилгааны ажилтан, өмгөөлөгчдөд зориулан 2008 оны 10 дугаар сард сургалт-семинар, 12 дугаар сард Нээлттэй нийгэм форумын сургагч багштай хамтран ЭЗТТ-ийн өмгөөлөгчийн ажил үүргийн онцлог, мэргэжлийн ур чадвар, арга зүйн талаар сургалт зохион байгуулсан байна. 2009 оны сургалтын төлөвлөгөөг тусгайлан боловсруулахаар бэлтгэж байна.

6 дахь зорилт: Орон нутагт эрх зүйн мэдээлэл, лавлагаа, хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх- 57%

❖ Нээлттэй нийгэм форумтай хамтран хэрэгжүүлсэн “Паралегал” төслийн хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтнуудад зориулсан “Эрх зүйн хөтөч” сургалт-семинарыг цуврал хэлбэрээр 4 удаа зохион байгуулж, сертификат олгосон байна. Сургалтыг эрх зүйн албан бус сургалтын сурах бичгийн дагуу явуулж, эрх зүйн хөтөчийн үйлчилгээг орон нутагт хэрхэн үр дүнтэй зохион байгуулах, “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, цаашид авах арга хэмжээний талаар чиглэл, заавар өгөн ажиллаж байна.

- ❖ Аймаг, дүүргийн ЗДТГ-ын дэргэд байгуулагдсан ЭЗТТ-үүд нь:
- Төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх
  - Харьяа нутаг дэвсгэрийнхээ иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх
  - Эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах чиг үүрэгтэй.

2008 оны 12 сарын байдлаар нийт 470 эрүүгийн хэргийн холбогдогчид үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлж, үүнээс 250 хэргийг бүрэн шийдвэрлүүлж дуусгаж, 1700 орчим иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгч, 1500 иргэнийг эрх зүйн албан бус сургалтанд хамруулсан байна. Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудтай хамтран иргэдэд Үндсэн хуулийн талаар мэдлэг олгох зорилготой эрх зүйн албан бус сургалтыг жил бүр тодорхой нэг өдөр цагт нэгдсэн журмаар орон даяар зэрэг 3 дахь жилдээ зохион байгуулсан байна. Сургалтанд улсын хэмжээнд нийт 2006 онд 5000, 2007 онд 3000, 2008 онд 8000 орчим иргэд хамрагдсан байна. Уг сургалт нь иргэдэд Үндсэн хуулийн талаар, тэр дундаа хүний эрх, эрх чөлөөний талаарх мэдлэгийг

иргэдэд системтэйгээр хүргэх зорилготой бөгөөд цаашид сургалтыг цуврал хэлбэрээр зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

❖ Эрх зүйн албан бус сургалт, зөвлөгөөний чиглэлээр цаашид баримтлан ажиллах чиглэл, ЗДТГ-ын эрх зүйн сургалт, сурталчилгааны ажилтны ажил үүргийн хуваарийн загварыг боловсруулж нийт аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт албан бичгээр хүргүүлсэн байна. Мөн хууль зүйн мэдээлэл, лавлагаа, зөвлөгөө өгөх, эрх зүйн албан бус сургалт, сурталчилгаа явуулах ажлын нэгдсэн мэдээ тайланг бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх, цаашид баримтлах чиглэлийг тодорхойлох зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 19 дүгээр тушаалаар “Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн хагас, бүтэн жилийн эрх зүйн ажлын мэдээний маягт” -ыг батлан хүргүүлсэн байна.

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих заалтуудаас хангалтгүй хэрэгжиж байгаа заалтуудыг дурдвал:

**I зорилтын хүрээнд** нийт 4 асуудал тусгагдсанаас биелэлт нь 100%-тай 1, 80%-тай 1, 70%-тай 1, 50%-тай 1 арга хэмжээ байна гэсэн үзүүлэлт гарч байна.

- Эрх зүйн туслалцааны төвүүдийн үйл ажиллагааг тогтворжуулах чиглэлээр хийгдэх ёстой ажлууд нь хугацааны хувьд 2008 оны 2 дугаар сараас эхлэн хийгдсэн бөгөөд Эрх зүйн төвүүд нь байгуулагдаад 4-8 сар болж байна. Төвүүдийн цаашдын тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор улсын төсвөөс цалингийн зардлыг санхүүжүүлэхээр шийдвэрлүүлсэн байна.

**III зорилтын хүрээнд** 2 асуудал тусгагдсанаас 60%-тай 1, огт хэрэгжээгүй 1 арга хэмжээ байна.

Хэрэгжээгүй байгаа заалтыг дурдвал:

- Эрх зүйн үнэ төлбөргүй туслалцааны чанарын болон хяналтын стандартыг Эрх зүйн туслалцааны төвүүдтэй хамтран боловсруулж батлуулан мөрдүүлэх.

**V зорилтын хүрээнд** 4 арга хэмжээ тусгагдсанаас 70%-тай 2, 50%-тай 1, 40%-тай 1, арга хэмжээ байна.

Хангалтгүй хэрэгжиж байгаа заалтаас дурдвал :

- Бүх хуулийн сургуулиудыг хууль зүйн клиниктэй болгох гэсэн заалтын дагуу хийгдэх ажил нь 2008 онд дууссан байхаар төлөвлөгдсөн боловч хэрэгжилт дунд шатандаа байна.

### **Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж**

Эдгээрээс үзэхэд “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд төлөвлөгдсөн арга хэмжээнүүдийн биелэлт нь **60,8** хувь буюу **3.5** оноотой байна.

Хөтөлбөр хэрэгжиж эхлээд 2 дахь жилдээ байгаа ч хэрэгжилтийн явц харьцангуй үр дүнтэй байна гэж үзлээ. Учир нь энэ хөтөлбөрийн төсөл, төсвийн санхүүгийн асуудлыг шийдвэрлэн нөөцийг төвлөрүүлэн зохион байгуулж, мэргэжилтэн, боловсон хүчнийг бэлтгэх, чадавхижуулах ажлууд амжилттай зохион байгуулагдсан байна.

Цаашид хугацаа хэтэрсэн хөтөлбөрийн заалтууд дээр нарийвчилсан төлөвлөгөө гарган дараахь саналуудыг анхааран ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

- Эрх зүйн орчныг боловсронгуй болгох
- Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх
- Төвийн эрх зүйн ажилтнууд, өмгөөлөгчдийн мэрэгжлийн ур чадварыг дээшлүүлж, чадавхижуулах ажлыг тасралтгүй үргэлжүүлэх
- Өмгөөлөгчдийн цуглуулах кредитийн сургалт, татвар хураамжийн асуудлыг анхааран үзэж хөнгөлөх нөхцөл боломжийг судлах
- Клиник сургалтын төвүүдтэй хамтран ажиллах замаар эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлын сүлжээг өргөжүүлэх
- Эрх зүйн туслалцааны төвүүдэд ашиглах гарын авлага, бусад материалын хүртээмж, хангамжийг нэмэгдүүлэх
- Зөвхөн Эрх зүйн туслалцааны төвүүдийн өмгөөлөгчдөөр хязгаарлагдахгүй, бусад өмгөөлөгчдийг төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажилд татан оролцуулах идвэхи санаачлагыг дэмжих
- Цаашид Эрх зүйн туслалцааны төвүүдийг орон нутгийн захиргааны байгууллагын бүтцэд оруулах эсэх, урсгал зардлын асуудлыг судлан шийдвэрлэх.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР



Танилцсан: Сайд ..... Ц.Нямдорж

Дэд сайд .....М.Төрбаяр

Зөвшөөрсөн: ТНБДарга .....Г. Баясгалан

Хянасан: МХШҮГ-ын дарга ..... Т. Бат-Өлзий

Боловсруулсан: МХШҮГ-ыг мэргэжилтэн Ц. Нугармаа